



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/387

Булган сум

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын даргыг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/400, 2022 оны А/480 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс”-ын даргаар ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (П.Оюунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/400 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”-ыг баримтлан комиссын бүрэлдэхүүнийг 5-7 гишүүнтэй байгуулж, тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагуудад хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (П.Оюунцэцэг)-т үүрэг болгосугай

3. Захирамжийн хэрэгжилтэд холбогдох хууль, тогтоомж, тушаалыг баримтлан хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т тус тус даалгасугай.

4. Тус захирамж гарсантай холбогдуулан 2022 оны А/654 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

